

**ИРГЭН
ТАНТАЙ
ЦАГДАА
ЯАЖ ХАРЬЦАХ
ЁСТОЙ ВЭ**



Гарын авлага



Монголын Эмнэлт
Интернэшнл
Фонд
address: 11/100/1000, Ulaanbaatar
www.mongolhrf.org
Yasu/Facebook: 224762



ИРГЭН ТАНТАЙ ЦАГДАА ЯАЖ ХАРЬЦАХ ЁСТОЙ ВЭ

Цагдаа нартай харьцах явдал өдөр тутам л тохиолддог. Энэ үед цагдаа тантай хэрхэн харьцах ёстойг та мэдэх үү? Энэ гарын авлага чухам энэ асуултад хариулах бөгөөд тантай яаж харьцах, ямар шалтгаанаар хүч хэрэглэх, хэрхэн хүч хэрэглэх тухай товч тайлбарлана. Энд дурдсан мэдээллийг та үндэслэл болгон цагдаагийн байгууллагын үйлчилгээний талаар гомдол гаргаж болно.

Яаж харьцах вэ?

Та хүн болохын хувьд хууль зөрчөөгүй л бол юу ч хийх эрхтэй бөгөөд ямар ч цагдаа ямар нэг тодорхой үндэслэлгүйгээр хэзээ ч таны эрхийг хязгаарлах ёсгүйг хамгийн түрүүнд санах хэрэгтэй. Иймээс цагдаа тантай харьцах хэрэгтэй гэж үзээд, тайван алхаж явахад чинь зогсоож байгаа бол эхлээд эелдэг найрсаг харьцах үүрэгтэй юм.

Цагдаа танд дөхөж ирээд:

- таны амрыг эрж
- өөрийгөө танилцуулаад
- үнэмлэхээ үзүүлэх ёстой.

Өөрийгөө танилцуулж, үнэмлэхээ үзүүлэх явдал маш чухал. Хэнтэй харьцаж байгаагаа мэдэх нь танд л хэрэгтэй. Би цагдаа байна гэж хэлэх нь мэдээж хангалтгүй. Тиймээс таныг зогсоож байгаа цагдаа болгон:

- аль дүүргийн, хорооны цагдаа
- ямар цолтой
- ямар үүрэг гүйцэтгэж яваа
- хэн гэдэг нэртэй
- хэд гэдэг дугаартай цагдаа гэдгээ хэлэх ёстой.

Өөрөөр хэлбэл “ахлах ахлагч Бат” гэж биш, харин “Чингэлтэй дүүргийн цагдаагийн хэлтсийн туслах жижүүр, 00000000 хувийн дугаартай цагдаагийн ахлах ахлагч Доржийн Бат” гэж танилцуулаад, үнэмлэхээ заавал үзүүлэх ёстой. Хэрвээ цагдаа өөрийгөө танилцуулахгүй бол тэр цагдаа дүрмээ зөрчиж

байгаа хэрэг, тиймээс та гомдол гаргах эрхтэй. Боломжтой бүх тохиолдолд танд үнэмлэхээ үзүүлж, өөрийгөө танилцуулах ёстой тухай дүрэмд нь заасан байдаг.

Таныг машинаа жолоодож явахад тань цагдаа зогсоовол өдрийн цагаар машиндаа сууж, оройн цагаар машинаасаа бууж цагдаатай харьцана.

Өдрийн цаг 06.00-22.00, оройн цаг 22.00-06.00

Цагдаа өөрийгөө танилцуулсны дараа үндсэн хоёр зүйлийг хэлж өгөх ёстой юм:

- Яах гэж таныг тухайлан зогсоож байгаагаа тайлбарлах үүрэгтэй. Таныг зүгээр явж байхад зогсоосон юм чинь яагаад зогсоосноо тайлбарлах нь зүй ёсны хэрэг шүү дээ. Хэрэв танд тайлбарлахгүй бол та тайлбарлахыг шаардах, бүр даргад нь гомдол гаргах эрхтэй.
- Хууль ёсны шаардлагаа тавих эрхтэй. Гэхдээ амандаа буувтаад өнгөрвөл эсвэл тодорхой хэлж өгөхгүй бол та лавлаж асуух эрхтэй шүү. Цагдаа танд үзлэг хийх шаардлага тавьбал:
- Цагдаа танд юуны учир үзлэг хийх гэж байгаа тайлбарлах үүрэгтэй. Хэрэв танд тайлбарлахгүй байвал та асууж мэдэх эрхтэй.
- Та 2-оос дээш гэрч, хэрэгтэй бол эмч байлцуулахыг шаардах эрхтэй. Халааснаас тань хутга гарсан гэж худлаа гүтгүүлэхгүйн тулд хөндлөнгийн гэрч танд заавал хэрэг болно. Та гэрч дуудах эрхтэй, харин таныг эрхээ эдлэхэд цагдаа туслах үүрэгтэйг бүү мартаарай.
- Таны нэр төрийг хөндөхөөргүй орчинд үзлэг хийх үүрэгтэй. Танд үзлэг хийж болдог юм гэхэд заавал түмний нүдэн дээр онгичоод, үзмэр болгож болохгүй шүү дээ. Олноос зайдуу газар ч юм уу, холхон үзлэг хийхийг та шаардах эрхтэй, цагдаа биелүүлэх үүрэгтэй.

Цагдаагийн албан хаагчийн хууль ёсны шаардлага гэж юу вэ

Олон нийтийн газар бусдын амгалан тайван байдлыг алдагдуулах, бусдыг айлгахаар догшин авирлах, танхайрах гэх

мэтчилэн захиргааны зөрчил эсхүл гэмт хэрэг үйлдэгдэж байна гэж үзсэн цагдаагийн алба хаагчаас уг үйлдлээ таслан зогсоохыг шаардаж, цаашид хийх үйлдлүүдийг зааж өгөх шаардлагуудыг хэлнэ.

Хэрхэн хүч хэрэглэх вэ?

Хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд таньд хуулийн дагуу гав бороохой, зэвсэггүй тулалдах мэх, байлдааны самбо карате болон галт зэвсгийг таны гаргасан зөрчил болон эсэргүүцэлд тохируулан хэрэглэх эрхтэй байдаг. Гэхдээ ямар тохиолдолд хэр хэмжээний хүч хэрэглэх, ингэхдээ ямар стандарт барих ёстойг хуульчлан заасан байдаг. Иргэн та энэ талаар өндөр мэдлэгтэй байвал цагдаагийн алба хаагчийн буруу үйлдэл, хүч хэтрүүлэн хэрэглэж буйг таслан зогсоож чадна. Ийм үйлдлийн талаар дуугүй өнгөрөлгүй та зохих байгууллагад хандан гомдол гаргахад л хангалттай.

Тусгай хэрэгсэл, мэхийг хуулийн үндэслэлгүй буюу буруу хэрэглэсэн зөрчлийг давтан гаргасан цагдаагийн алба хаагчийг энэ албанд ажиллах найдваргүй хүн гэж үздэг тул таны эрхийг зөрчихөөд дахин нэг хүний эрхийг зөрчихөөс нь сэргийлж та заавал гомдол гаргах хэрэгтэй. Цагдаагийн алба хаагч танд хүч, тусгай хэрэгсэл хэрэглэсэн үед та доорхи зүйлийг анхаараарай.

Гав зүүх, хүлэг, уяа хэрэглэх

Цагдаагийн алба хаагч нь гавыг хэрэглэхдээ хүйтний улиралд хүний биеийн ил хэсэг хайрагдахаас эсхүл үл хөдлөх зүйлтэй холбон гавлахдаа тухайлбал халуун пааранд түлэгдэх зэргээс сэрэмжлэн гавлах ёстой.



Цагдаагийн алба хаагч нь гав хүний биед шигдэн орох, чангаран судсыг нь боох зэргээс сэрэмжлэн тодорхой хугацаанд ойр ойрхон шалгаж байх ёстой байдаг. Цагдаагийн алба хаагчийн шаардлагыг эсэргүүцэгч гараа хүлүүлсэн ч эсэргүүцлээ зогсоохгүй бол дөрвөлжин хүлгийг хэрэглэдэг. Гэвч энэ хүлгийг 1 цагаас илүү хугацаагаар хэрэглэж болохгүй гэж хуульд заасан байдаг. Мөн хүүхэд болон жирэмсэн болох нь илэрхий мэдэгдэж байгаа хүнд хэрэглэдэггүй. Мөн гавыг стандартын гав мөн эсэхэд хяналт тавихад илүүдэхгүй шүү.

Бороохойдох

Цагдаагийн алба хаагчийн хууль ёсны шаардлагыг зориуд биелүүлээгүй, илт эсэргүүцсэн, хамгаалалтанд байгаа объект руу довтолсон, бүлэглэн довтолсон, гэмт хэрэг зөрчил үйлдэгдэж байгаа үед уг үйлдлийг



таслан зогсоох, хамгаалах зорилгоор резинэн болон цахилгаан бороохойг хэрэглэдэг.

Резинэн бороохойгоор хүний биений толгой болон хэвлий, зүрхэн тус газар, бөөрний харалдаа, нуруун тус газар зохихыг хориглодог. Цахилгаан бороохойгоор хүний нүүрэн тус газар, биеийн ил хэсэгт хэрэглэхийг хориглодог. Иргэн таныг стандартад нийцсэн

резинэн бороохойгоор бороохойдож буй эсэхэд мөн анхаараарай.

Цагдаагийн алба хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлээгүйгээс учирсан болон эсэргүүцэл үзүүлсэнээс үүссэн хохирлыг та өөрөө хариуцна. Харин танд хууль бусаар хүч хэрэглэн хохирол учруулбал, мөн эсэргүүцээгүй байхад хориглосон газруудад бороохойдсон бол буруутай цагдаагийн алба хаагч буюу төр таны хохирлыг 100% барагдуулах үүрэгтэй.

Жагсаал цуглааны үеэр хүч хэрэглэх

Цагдаагийн байгууллага олон нийтийг хамарсан үймээн самууны үед үймээн самууныг зогсоох, гэмт хэргээс сэргийлэх, гол буруутанг баривчлах, бусад иргэдийн эрхийг хамгаалах үүднээс усан хөөрөг, утаан хөшиг, нулимс асгаруулагч зэрэг олон хүнд нөлөөлөх тусгай зэвсэг хэрэглэх эрхтэй. Энэ үеэр цагдаагийн алба хаагч нь өөрсдийн хөдөлмөр хамгааллын багаж хэрэгсэл болох дуулга, бамбай, хантааз зэргийг өмсөж, гав бороохой, нулимс асгаруулагч гэх мэт тусгай хэрэгсэлээ бүрэн авч явах эрхтэй. Та үүнд нь дургүйцэн иргэдийнхээ өмнөөс зэвсэг барин зогслоо, шүдээ хүртэл зэвсэглэлээ гэж дайрч доромжлох ёсгүй. Аливаа жагсаал цуглааны үеэр болзошгүй үймээн самуун, олон нийтийн амгалан тайван байдлыг хангах үүднээс ажиллаж буй цагдаагийн байгууллагын хууль ёсны үйл ажиллагаа, шаардлагыг иргэн та хүндэтгэх ёстой. Гэхдээ энэ нь таныг



цагдаагийн байгууллагын хууль бус үйл ажиллагаа, хууль бус шаардлагыг хүлцэн тэвч, эсхүл хайхаралгүй орхи гэсэн үг биш шүү. Ямар нэг нийтийг хамарсан үймээн самуун гаргаагүй, тайван замаар хийж буй аливаа жагсаал цуглааны үеэр цагдаа нар хүч хэрэглэх эрхгүй. Зөвхөн байдлыг ажиглан, хамгаалалтын бэлэн байдалд байх үүрэгтэй.

Галт зэвсэг хэрэглэх

Цагдаагий алба хаагчийн болон бусад хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол, учруулж болзошгүй байдлаар довтолсон, хамгаалалтанд байгаа объект руу халдсан, зэвсэглэж буюу бүлэглэн довтолсон, шаардлагыг үл биелүүлэн зугатаасан, хүнийг барьцаанд авсан, ялтан, цагдан хоригдож байгаа хүн оргосон, онц хүнд гэмт хэрэгтэн зугатахаар оролдсон, эсхүл довтолсон, хуяглан хүргэж байгаа этгээдийг суллахаар зэвсэглэн, эсхүл бүлэглэн довтолсон, хорих цагдан хорих байранд эмх замбараагүй байдал үүсч бусдын эд хөрөнгө, амь насанд бодит хохирол учруулах нөхцөл үүссэн бол Цагдаагийн алба хаагч нь галт зэвсэг хэрэглэх эрхтэй. Гэхдээ боломжтой бүх тохиолдолд галт зэвсэг хэрэглэх гэж байгаа тухайгаа сануулах ёстой байдаг.

Зарим цагдаагийн алба хаагч албаны буу зэвсэг тусгай хэрэгсэлийг хувийн зорилгоор ашиглах, тодорхой үндэслэл бүрдээгүй байхад буруу хэрэглэх, зөрчилд тохироогүй хүч хэтрүүлэн хэрэглэх явдал гаргадаг. Өөрөөр хэлбэл мэргэжлийн алдаа гаргаж байна гэсэн үг. Мэргэжлийн цагдаатай болохын тулд та ийм үйлдлийг харсан л бол дуугүй өнгөрөлгүй гомдол саналаа зохих байгууллагуудад нь гаргаарай.



Хүч хэрэглэсний дараа

Цагдаагийн байгууллагын алба хаагч албан үүрэг гүйцэтгэх явцдаа бусдад хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэсний дараа тухайн этгээдийн эсэргүүцэл зогссон үед эмнэлгийн анхны тусламжийг яаралтай үзүүлэх үүрэгтэй байдаг.

ХҮНИЙГ ХҮНДЭТГЭДЭГ СОЁЛТОЙ ЦАГДААГ ИРГЭН ТА ӨӨРӨӨ БИЙ БОЛГОНО

Яаж гэж та асуумаар байна уу. Хариулт нь та тэдний ажил албандаа баримтлах ёстой стандартийг мэдээд, үүнийгээ хэр биелүүлж байгаад хяналт тавиад, буцаад холбогдох байгууллагад нь хандах хэрэгтэй. Ингээд л гүйцээ.

Цагдаагийн эрхэм зорилго юу вэ

Гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах, урдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлж, иргэд байгууллага, аж ахуйн нэгжийн амгалан тайван байдал, амьдрах нөхцлийг бүрдүүлэх, тэдэнд цагдаагийн ажил үйлчилгээг шуурхай хүргэж, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн үйл ажиллагаагаа хуулийн хүрээнд явуулахад оршино.

Иргэн бид цагдаагаас юу хүсдэг вэ

Иргэн бүр цагдаагийн алба хаагчаас туйлын эелдэг даруу харьцаа, соёлч байдал, ухаалаг, бусдад халамжтай, шударга, төрийн төлөөлөгч байхыг хүсдэг. Өөрөөр хэлбэл цагдаагийн алба хаагчийн хийж гүйцэтгэж байгаа үйл хөдөлгөөн, зан төрх байдал, үг яриа мэргэжлийн өндөр түвшинд байх ёстой гэсэн үг.

Цагдааг ямар болгох хэрэгтэй байна вэ

Цагдаагийн алба хаагч нь иргэдэд үйлчилж байгаагаа ямагт санаж, иргэдтэй харьцахдаа ёсолж хүндэтгэж, өөрийн алдар цол, нэрээ

хэлж, ажил хэргээ танилцуулан, иргэд үнэмлэхээ үзүүлэхийг хүсвэл татгалзахгүйгээр үзүүлэх ёстой. Ялангуяа доорхи стандартыг чанд баримталдаг болох ёстой. Үүнд:

А. МЭДЭЭЛЭЛ ХҮЛЭЭН АВАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СТАНДАРТ

Үйлчлүүлэгчтэй зөв боловсон найрсгаар харьцана. Жишээ нь: утсаар харилцаж байгаа тохиолдолд “Амрыг эрье”, дүүргийн цагдаагийн хэлтсийн туслах жижүүр, цагдаагийн ахлагч цолтой сонсож байна. “Танд юугаар тусалж болохсон бол?” гэж яриад холбогдох мэдээллийг хүлээн авна.

- Шаардлагатай бол хэргийн газрыг хамгаалалтад авах ажлыг зохион байгуулна.
- Хэргийн газрын үзлэг дээр бүрэлдэхүүн шуурхай очно.
- Хохирогч нартай уулзан тэдний яриад анхааралтай сонсож холбоо тогтооно.
- Гомдол гаргагч, мэдээлэл өгөгчийг өөр байгууллага, хүний нэр зааж хүсэлтийг нь хүлээн авахгүйгээр буцаан явуулж болохгүй. Харин иргэний харьяаллын асуудал байвал засаг захиргаа, шүүхэд алинд нь хандахыг зөвлөнө.
- Үйлчлүүлэгчтэй эелдэг боловсон харьцаж, үйлчлүүлсэн явдалд танд баярлалаа гэж сэтгэгдлээ илэрхийлнэ.

Б. ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, МЭДЭЭЛЛИЙГ ШАЛГАЖ ШИЙДВЭРЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СТАНДАРТ

Гэмт хэргийн шинжтэй өргөдөл, гомдол, мэдээллийг 5 хоногийн дотор хянаж эрүүгийн хэрэг үүсгэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ. Уг асуудлыг шалгахад нэмэлт ажиллагаа шаардлагатай бол алба, байгууллагын даргаар 14 хоног хугацаагаар сунгуулна. Санал, хүсэлтийг 30 хоногийн дотор шалгаж шийдвэрлэнэ.

- Уг асуудлыг хэрхэн яаж шалгах тухайгаа өргөдөл, гомдол гаргагч, мэдээлэл өгөгчид тодорхой ойлгуулна.

- Өргөдөл, гомдол, мэдээллийг шалгах явцад хүний бие, эд зүйл, орон байранд үзлэг хийх шаардлагатай бол хөндлөнгийн гэрч байлцуулан учрыг тайлбарлаж, үзлэг хийсэн тэмдэглэлд хөндлөнгийн гэрч байлцуулан учрыг тайлбарлаж, холбогдох бусад хүмүүсээр гарын үсэг зуруулна.

- Шалгалтын явцад хүнээс эд зүйл, бичиг баримт түр хураан авах, Эд хөрөнгийг битүүмжлэх бол хөндлөнгийн гэрч байлцуулан тэмдэглэл хөтөлж, гарын үсэг зуруулан нэг хувийг эзэнд нь үлдээнэ.

Өргөдөл, гомдол гаргагч, мэдээлэл өгөгч шийдвэрийг зөвшөөрөхгүй тохиолдолд гомдлоо прокурорт хандах тухай тайлбарлаж өгнө.

V. ХЭРЭГ БҮРТГЭХ, МӨРДӨН БАЙЦААХ АЖИЛЛАГААНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СТАНДАРТ

- Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нь хохирогч, гэрчтэй яаралтай уулзаж холбоо тогтоож, хэрэг учралын талаар ярих боломжийг тэдэнд олгож, яриаг нь таслахгүй сонсоно.

- Тэдэнтэй эелдэг харьцаж өөрийн зүгээс явуулах үйл ажиллагааг ойлгогдохоор тайлбарлана.

- Хохирогч гэрчээс тодорхойлолт, байцаалт авсны дараа талархал илэрхийлнэ. Өөртэйгөө шууд харилцах утсыг өгнө.

- Хэргийн шалгалтын явцын талаар хохирогчтой хэрхэн яаж харилцах арга, боломжоо тохирно.

- Гэмт хэрэг үйлдсэн байж болох сэжигтэй этгээдийг баривчилсан бол түүнд учрыг тайлбарлаж, өмгөөлөгч авахыг зөвлөнө.

- Сэжигтэй этгээдийг баривчилсан тухай түүний гэр бүлийн насанд хүрсэн гишүүн, төрөл садангийн хүн эсвэл өмгөөлөгчид нь мэдэгдэнэ.

- Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчидтой эелдэг боловсон харилцана.

- Хэрэг шалгах явцад эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдыг чирэгдүүлэхгүй, тэдэнд цагдаагийн үйлчилгээг шуурхай хүргэхийн тулд ажилаа зөв зохион байгуулахад ямагт анхаарна.

Хэргийг шалгаж буй үйл ажиллагааны явцад хэрэгтэн, яллагдагч, хохирогч, гэрч, нэхэмжлэгчээс хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн үйл ажиллагаа, шийдвэрийн талаар гомдлыг тухайн алба, байгууллагын даргад гаргаж болно. Гомдлыг хүлээн авсан албан тушаалтан 72 цагийн дотор шийдэх ба нэмэлт ажиллагаа хийх буюу бусад арга хэмжээ авах хэрэгтэй бол ажлын 7 хоногийн дотор шалгаж хариу өгнө.

G. НИЙГМИЙН ХЭВ ЖУРАМ ХАМГААЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СТАНДАРТ

- Иргэд, аж ахуй нэгж, байгууллагын эзэмшилд байгаа галт болон хүйтэн зэвсэг, үйлдвэрлэлийн зориулалттай тэсэрч дэлбэрэх, хүчтэй үйлчлэх химийн хорт болон цацраг идэвхит бодис, сургалтын зориулалтын галт зэвсэг, техникийг бүртгэлд авч, хяналт тавина.

- Хар тамхи, мансууруулах бодис хэрэглэдэг, согтууруулах ундаа хууль бусаар үйлдвэрлэдэг, борлуулдаг иргэдийн үйл ажиллагааг таслан зогсоох арга хэмжээ авна.

- Иргэд байгууллагаас ирүүлсэн гэмт хэрэг, зөрчлийн тухай мэдээллийг нэн даруй хүлээн авч, холбогдох арга хэмжээ авна.

- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, сонор сэрэмжтэй байх тухай мэдээллийг иргэд, байгууллагад шуурхай хүргэнэ.

- Тухайн хүнтэй холбогдох асуудлыг шалгах бол түүнд үндэслэл, учрыг тайлбарлаж өгнө.

- Шалгасан үндэслэл, тогтоогдоогүй тохиолдолд түүнээс уучлал хүснэ.

ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИЙН ТАЛААР ГОМДОЛ ГАРГАХ ГАЗАР

1. Тухайн цагдааг харъяалах газрын дээд шатны эрх бүхий албан тушаалтнууд
2. Нийслэлийн цагдаагийн газрын Хэв журмын хэлтсийн Ёс журмын алба
3. Улсын Ерөнхий Прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах алба



Бүх аймаг, сум, дүүргийн цагдаагийн газар хэлтсүүдэд хариуцлагатай зохицуулагч, ерөнхий эргүүл 24 цагаар ажиллаж өөрийн байгууллагын алба хаагчтай холбоотой сахилга, ёс зүйн талаархи гомдол мэдээллийг хүлээн авч байдаг тул эхний ээлжинд та хандаарай.

Цагдаагийн алба хаагчийн гаргасан ёс зүйн зөрчлийн талаархи гомдлыг Нийслэлийн цагдаагийн газрын Хэв журмын хэлтсийн Ёс журмын албанд гаргана. 24 цагийн туршид иргэдийн гомдол саналыг хүлээн авч шийдвэрлэдэг тул та **Утас 321515** руу ямар ч үед утасдаж эсхүл өөрийн биеэр очиж, бичгээр болон амаар гомдлоо гаргаж болно.

Цагдаагийн байгууллагын алба хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлж байхад тань таныг цээрлүүлэх байдлаар хүч хэрэглэх, хориотой газар бороохойдох зэргээр халдсан эрүүгийн шинжтэй аливаа үйлдлийн талаар та Улсын Ерөнхий Прокурорын дэргэдэх Мөрдөн Байцаах Албанд хандаж гомдол гаргах эрхтэй.

Утас 319313, факс 315514
цахим шуудан: info@epmba.in.mn

Соёлтой боловсон цагдааг иргэн та өөрөө бий болгож чадна

Иргэн та “Миний цагдаа намайг хамгаална” гэсэн сэтгэлээр итгэж, төрийн төлөөлөгчийг хүндэтгэн харьцах нь зүйтэй. Цагдаагийн алба хаагчийн хууль ёсны шаардлагыг зориуд биелүүлэхгүй байх, албан үүргээ биелүүлэхэд нь санаатайгаар саад учруулах, албан үүрэгтэй нь холбогдуулан цагдаагийн алба хаагч, чөлөөнд гарсан цагдаагийн ажилтныг доромжлох, гүтгэх, заналхийлэх, хүч хэрэглэх зэрэг зохисгүй үйлдлийг бүү гаргаарай.



Үүний нэгэн адилаар, хууль бус шаардлага тавин, түүнийгээ төрийн нэрээр сүр далайлган биелүүлэхийг шаарддаг, шаардлагагүй тохиолдолд зандчин хашгирах эсхүл хүч хэрэглэдэг бүдүүлэг, мэргэжлийн бус цагдаагийн алба хаагчийн талаар холбогдох газруудад нь мэдээлж, **хариуцлага тооцож сураарай**. Ингэж чадвал бид мөрөөдлийнхөө цагдааг бий болгоно.

Монголын Эмнести Интернэшнл

Сүхбаатар дүүрэг,
6-р хороо,
Бага тойруу - 44,
10 тоот
Утас/факс:
976-11-324705
Цахим шуудан:
aimncc@magicnet.mn
www.amnesty.mn

